

**“ДУЛААНЫ МАГИСТРАЛЬ ШУГАМЫН ӨРГӨТГӨЛИЙН ЗУРАГ ТӨСӨЛ  
/УЛААНБААТАР/” АЖЛЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХЭЭР ЗАХИАЛАГЧ,  
ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭ**

**(НИЙТ ҮНЭД ҮНДЭСЛЭСЭН ГЭРЭЭ)**

Улаанбаатар  
2021 он  
БАТЛАВ.



**“ДУЛААНЫ МАГИСТРАЛЬ ШУГАМЫН ӨРГӨТГӨЛИЙН ЗУРАГ ТӨСӨЛ  
УЛААНБААТАР” АЖЛЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХЭЭР ЗАХИАЛАГЧ,  
ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭ**

2021 оны <sup>06</sup> дугаар  
сарын <sup>16</sup> -ны өдөр

Дугаар:...../158

Улаанбаатар хот

Нэг талаас Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төв (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Эрчим төсөл” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, Барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу зөвлөх үйлчилгээг үзүүлэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/” төсөл арга хэмжээний хүрээнд хэрэгжих **“ДУЛААНЫ МАГИСТРАЛЬ ШУГАМЫН ӨРГӨТГӨЛИЙН ЗУРАГ ТӨСӨЛ УЛААНБААТАР”** ажлын зөвлөх үйлчилгээг – **162,000,000 /нэг зуун жаран хоёр сая/** төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний нийт дүн: **162,000,000 /нэг зуун жаран хоёр сая/** төгрөг.  
Үүнээс: Улсын төсвөөс:  
2021 онд **129,600,000 /нэг зуун хорин есөн сая зургаан зуун мянга/** төгрөг  
2022 онд **32,400,000 /гучин хоёр сая дөрвөн зуун мянга/** төгрөг
4. Гүйцэтгэгч нь “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/” төсөл арга хэмжээний хүрээнд хэрэгжих **“ДУЛААНЫ МАГИСТРАЛЬ ШУГАМЫН ӨРГӨТГӨЛИЙН ЗУРАГ ТӨСӨЛ УЛААНБААТАР”** ажлын зөвлөх үйлчилгээг 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр эхэлж, 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад оруулна.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 5.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
  - 5.3 Тендер;

- 5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6 Техникийн тодорхойлолт;
- 5.7 Зураг;
- 5.8 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь;
- 5.9 Санхүүжилтийн хуваарь;
- 5.10 Ажил гүйцэтгэх хуваарь.

- Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
  7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
  8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
  9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.


**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**


Барилга, хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

“Эрчим төсөл” ХХК-ийн инженер



Э.ГАНХҮҮ



А.ЭНХБАТ



А.ЦОГТ

Барилга, хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Эрчим хүчний яамны ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн дарга

“Эрчим төсөл” ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч



Л.МӨНХЖАРГАЛ



Б.САЙНЖАРГАЛ-2

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга - 2

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирал

УЛААНБААТАР ХОТ



Я.НЯМЖАРГАЛ



Б.НЯМДОРЖ

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Захиалагчийн хяналтын хэлтсийн дарга



Л.БАТХҮҮ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12 дугаар байр

Утас: +976 76003333

Факс: +976 0322904

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, Засгийн газрын XIV байр, өргөтгөл

Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төв

Утас: 62263051, 77116050

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороолол, 10-р хороо, Их тойруу -60, Барилгын дэвшилтэт технологийн төв (503, 504, 506, 508 тоот)

Утас: 976-11-354280

Факс: 976-7013-5003

Цахим хаяг:

[tsogta@yahoo.com](mailto:tsogta@yahoo.com)

РД: ХИ54111371

Банк, дансны дугаар:

ХХБанк 404027480

утас №: 99099754

## II. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### 1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- 1.1 Нэр томъёоны тайлбар**
- 1.1 Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
- (а) “Гэрээнд хэрэглэх хууль” гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ.
  - (б) “Зөвлөх” гэж захиалагчтай байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа аливаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ.
  - (в) “Гэрээ” гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ.
  - (г) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
  - (е) “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ.
  - (д) “Гэрээний үнэ” гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Зөвлөхөд төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ.
  - (е) “ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцөлийг хэлнэ.
  - (ё) “Гишүүн” гэж түншлэл /консорциум/ холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг “Гишүүд” гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ.
  - (ж) “Гэрээний тал гэж” Захиалагч эсхүл Зөвлөхийн аль нэгийг, харин “Талууд” гэж хоёуланг нь хэлнэ.
  - (з) “Нөхөн төлөх зардал” гэж зөвлөхийн ажлын хөлснөөс бусад үйл ажилгаатай холбоотой бүх зардлуудыг хэлнэ.
  - (л) “ГТН” гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ.
  - (м) “Үйлчилгээ” гэж Хавсралт №1-т тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Зөвлөхийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ.
  - (о) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Зөвлөхтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
  - (ө) “Ажиллах хүчин” гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Зөвлөхийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.

- |   |  |
|---|--|
| <b>1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль</b>              | Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.  |
| <b>1.3 Гэрээнд ашиглах хэл</b>                    | Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.  |
| <b>1.4 Мэдэгдэл</b>                               | Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой.   |
| <b>1.5 Байршил</b>                                | Үйлчилгээг, гэрээний хавсралт №1-т заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харъяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстой.   |
| <b>1.6 Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ</b> | Зөвлөх нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно.   |
| <b>1.7 Итгэмжлэгдсэн төлөөлөгч</b>                | Гэрээний дагуу захиалагч эсхүл зөвлөхийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.  |
| <b>1.8 Татвар, хураамж</b>                        | Зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой.  |
| <b>1.9 Авилгал болон залилан мэхлэх үйлдэл</b>    | Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч зөвлөх бүр худалдан авах ажиллагаанд оролцох, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.<br><br>Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон зөвлөх нь Авилгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авилгал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ. |

## **2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ**

- |                                       |  |
|---------------------------------------|--|
| <b>2.1 Гэрээ хүчин төгөлдөр болох</b> | Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан, эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ. |
|---------------------------------------|--|

- 2.2 **Үйлчилгээг эхлэх** Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой.
- 2.3 **Гэрээний хугацаа дуусгавар болох** ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хугацааны дараагаар энэхүү гэрээний хугацаа дуусгавар болно.
- 2.4 **Гэрээний өөрчлөлт буюу засвар** Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно.
- 2.5 **Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл** 2.5.1 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол талууд тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана.

Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Зөвлөх гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.

## 2.6 Гэрээ цуцлах

### 2.6.1 Захиалагч гэрээг цуцлах

Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.

- (а) Зөвлөх гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй;
- (б) Зөвлөх (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа;
- (в) Зөвлөх нь тендерт оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа;
- (г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
- (д) Захиалагч өөрийн санаачлагаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол:

- (e) Зөвлөх ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрагийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй:

### **2.6.2 Зөвлөхийн санаачлагаар гэрээг цуцлах**

Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөвлөх өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй

- (a) захиалагч нь ГЕН-ийн 7 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг зөвлөхийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй
- (б) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон:
- (в) Захиалагч ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрагийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй:
- (г) Захиалагч гэрээний дагуу хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү зөрчлийн талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 45 хоногийн хугацаанд ( эсхүл зөвлөхийн бичгээр зөвшөөрөн сунгасан хоногт багтаан) тухайн зөрчлийг арилгаагүй:

### **2.6.2 Гэрээг цуцласан үед хийх төлбөр**

ГЕН-ийн 2.9.1 болон 2.9.2 зүйлд заасны дагуу гэрээг цуцласан үед захиалагч дараах төлбөрийг зөвлөхөд төлөх ёстой:

- (a) Гэрээг цуцлах өдрөөс өмнө зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу төлбөл зохих үйлчилгээний хөлс:
- (б) ГЕН-ийн 2.6.1-ийн (а)-гаас (в) хүртлэх, мөн (е) заалтын дагуу гэрээг цуцалснаас бусад тохиолдолд зөвлөхийн ажилтнууд, тэдний хууль ёсны хамтран амьдрагч нарыг буцаах замын зардал зэрэг гэрээг цуцласны улмаас үүсэх аливаа бодит зардлын нөхөн олговор:

## **3. ЗӨВЛӨХИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

### **3.1 Ерөнхий зүйл**

#### **3.1.1 Гүйцэтгэлийн чанар**

Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материаллын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.

Зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.

- 3.2 Ашиг сонирхлын зөрчил** Зөвлөх нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстой бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхолын зөрчилд орохоос зайлсхийх ёстой.
- 3.3 Нууцлал** Зөвлөх, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан аливаа нууц мэдээллийг ямар нэгэн хувь хүн, байгууллагад дамжуулах эрхгүй бөгөөд үйлчилгээний үр дүнд боловсруулсан зөвлөмжийг нийтэд нээлттэй болгох эрхгүй
- 3.4 Зөвлөхийн хариуцах даатгал** Зөвлөх нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзолын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.
- 3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа** Зөвлөх нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд:
- (а) Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,
  - (б) Хавсралт №1-т заасан ажилтны жагсаалтанд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.
  - (в) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа
- 3.6 Тайлагнах хуваарь** Зөвлөх нь Хавсралт №2 -т заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстой.
- 3.7 Зөвлөхийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь** Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хүргүүлнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.
- 3.8 Нягтлан бодох бүртгэл, Хяналт шалгалт болон Аудит** Зөвлөх нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

#### 4. ЗӨВЛӨХИЙН АЖИЛТНУУД

- 4.1 Ажиллах хүчний тодорхойлолт** Зөвлөхийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Хавсралт №3-т тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтанд багтаана.
- 4.2 Ажилтныг халах буюу солих** (а) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Зөвлөхийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү

буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй тавина.

- (б) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстой.
- (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсч болох ямар нэгэн нэмэлт зардлыг зөвлөх нэхэмжлэх эрхгүй болно.

## 5. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 5.1 Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох** Захиалагч нь ГТН-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг засгийн газрын зүгээс олгуулахын тулд бүх талын хүчин чармайлт гаргана.
- 5.2 Гэрээнд хэрэглэх хуулинд татвар хураамжийн талаар орсон өөрчлөлт** Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуулинд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Зөвлөхийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиролцон гэрээний дагуу Зөвлөхөд төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой.
- 5.3 Захиалагчийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгө** Захиалагч нь үйлчилгээний зорилгоор ашиглуулахаар Хавсралт 3.3-д заасан үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг тогтоосон хугацаанд үнэ төлбөргүйгээр Зөвлөхөд гарган өгөх ёстой.

## 6. ЗӨВЛӨХӨД ТӨЛӨХ ТӨЛБӨР

- 6.1 Нийт төлбөр** Зөвлөхөд төлөх нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний хавсралт №1-т тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчлөснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно.
- 6.2 Гэрээний үнэ**
  - (а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
  - (б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
- 6.3 Нэмэлт үйлчилгээний төлбөр** ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг Хавсралт №4 болон №5-д оруулна.

**6.4 Төлбөр хийх нөхцөл.хуваарь** Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан зөвлөхийн дансанд хийнэ. ГТН-д өөрөөр заагаагүй бол, түүнд тогтоосон хугацаанд хүчинтэй байхаар тооцож, зөвлөхийн ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнтэй тэнцэх хэмжээгээр эхний төлбөрийг хийнэ. Энэхүү баталгааг Хавсралт №7-д заасан маягт, эсхүл захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрсөн өөр маягтаар гарган ирүүлнэ.

ГТН-д заасан нөхцөл болзолыг хангасны дараа, зөвлөхөд төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстой.

**6.5 Хугацаа хоцорсон төлбөрийн хүү** Захиалагч нь ГТН-ийн 6.4-д тогтоосон төлбөр хийх хугацааг арван таван хоногоос (15) дээш хоногоор хэтрүүлсэн бол хугацаа хоцорсон хоног тутам ГТН-д тогтоосон хэмжээгээр зөвлөхөд хүү төлөх ёстой.

## **7. ШУДАРГА БАЙДАЛ**

**7.1 Шударга байдал** Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биенийхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгыг хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.

## **8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ**

**8.1 Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх** Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтанд ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө.

Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

**8.2 Маргааныг шийдвэрлэх** Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.

### III. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН-ийн зүйлийн дугаар	Гэрээний ерөнхий нөхцлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчлөнө.
{1.1(а)}	Гэрээнд хэрэглэх хууль нь { Монгол Улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актууд}
1.3	Гэрээний баримт бичгүүд нь <b>Монгол</b> хэл дээр байна.
1.4	<p><b>Захиалагч:</b> Барилга, хот байгуулалтын яам</p> <p>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Засгийн газрын 12 дугаар байр,</p> <p>Харилцах хүн: Барилга, хот байгуулалтын яамны Хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн Ж.Орхонбаяр, Утас: 99017228</p> <p><b>Захиалагч:</b> Эрчим хүчний яам</p> <p>Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Засгийн газрын 14 дүгээр байр,</p> <p>Харилцах хүн: Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч П.Жаргалсайхан, Утас: 88093049</p> <p><b>Захиалагчийн хяналт гүйцэтгэгч:</b> “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ</p> <p>Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,</p> <p>Харилцах хүн: “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Захиалагч, хяналтын хэлтсийн дарга Л.Батхүү, Утас: 80110503</p> <p><b>Зөвлөх:</b> “Эрчим төсөл” ХХК</p> <p>Сүхбаатар дүүрэг, 7-р хороолол, 10-р хороо, Их тойруу -60, Барилгын дэвшилтэт технологийн төв ( 503, 504, 506, 508 тоот), Утас: 976-11-354280 Факс: 976-7013-5003</p> <p>Харилцах хүн: “Эрчим төсөл” ХХК-ийн инженер А.Цогт, Утас: 99099754, Цахим хаяг: <a href="mailto:tsogta@yahoo.com">tsogta@yahoo.com</a></p>
1.7	<p><b>Итгэмжлэгдсэн төлөөлөгчид:</b></p> <p><b>Захиалагчийн:</b> Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Д.Оюунтунгалаг, Утас:99102172,</p> <p><b>Захиалагчийн хяналт гүйцэтгэгч:</b> “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Захиалагч, хяналтын хэлтсийн ахлах инженер Г.Бат-Очир, Утас:99035343,</p> <p><b>Зөвлөхийн:</b> “Эрчим төсөл” ХХК-ийн инженер А.Цогт, Утас: 99099754, Цахим хаяг: <a href="mailto:tsogta@yahoo.com">tsogta@yahoo.com</a></p>

1.8	<b>Татвар:</b> Зөвлөх нь ажлыг гүйцэтгэхтэй холбогдон төлөгдөх бүх татвар, хураамж, шимтгэлийг төлөх асуудлыг өөрсдөө хариуцна. Зөвлөхийн ирүүлэх үнийн саналд хуулийн дагуу төлөх татвар, даатгал, хураамж, багтсан байна.
2.2	<b>Тогтоосон хугацаа:</b> Гэрээ байгуулсан өдрөөс эхэлнэ.
2.3	<b>Тогтоосон хугацаа:</b> Зургийн даалгаварт заасан хугацаа /2022 оны 01 сарын 20-ны өдөр/ дуусна.
{3.5 (в)}	Бусад үйл ажиллагаа: <b>Захиалагч нь зураг төслийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөх, техникийн нөхцөл гаргуулах, магадлалаар хянуулж батлуулах зэрэг ажилд зөвлөхөд дэмжлэг, туслалцаа үзүүлж холбогдох зөвшөөрлийг олгуулахын тулд бүх талын хүчин чармайлт гаргана.</b>
6.2(б)	Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: <b>162,000,000 (Нэг зуун жаран хоёр сая)</b> төгрөг
6.4	<p>Төлбөр хийх данснууд: <i>Худалдаа хөгжлийн банк 404027480</i></p> <p>Төгрөгийн хувьд: <b>162,000,000 (Нэг зуун жаран хоёр сая) төгрөг</b></p> <p><b>Төлбөрийг дараахь хуваарийн дагуу төлнө.</b>  <b>Тэмдэглэл: (а) дор дурдсан төлбөрийн хуваарь нь зөвхөн дүн шинжилгээ хийх, жишээ болох зорилготой; (б) гадаад мөнгөн тэмдэгт болон төгрөгөөр хийх хуваарь харилцан адилгүй бол салангид хуваарь гаргаж мөрдөнө.</b></p> <p>а) Гэрээний үнийн дүнгийн 40 хувьтай тэнцэх дүнг эхлэлийн шатны тайланг хүлээн авч эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурснаар төлнө. Эхлэлийн шатны тайлан дараах бүтэцтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Дулааны 10 ВГД магистраль шугамын ОЦ-1050 /ТК703/-р цэгээс насос станц №3 хүртлэх 2ф800 мм-н голчтой шугамыг 2ф1000 м-ийн голчтой болгож өргөтгөх”, “трассын дагуух ф300 мм-н голчтой цэвэр усны шугамыг ф500 мм голчтой болгож өргөтгөх”, дулааны 10 ВГД магистрал шугамын дагуух үйлдвэрийн уурын шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлсэн тухай тайлан</li> <li>- Газар нутаг орчны байдал , ерөнхий төлөвлөгөө дулаан, цахилгаан, ус хангамж, бохир усны шугамын өнөөгийн байдлын суурь судалгаа</li> <li>- “Дулааны магистраль шугамын өргөтгөлийн зураг төсөл /Улаанбаатар/” ажлын зураг төсөл боловсруулах ажлын дэвсгэр зураг, инженер геологийн ажлын тайлан.</li> <li>- Трассын төлөвлөлтийг УБ хотын газрын алба, хот байгуулалт төлөвлөлтийн газар болон холбогдох инженерийн байгууллагуудаас тодруулга авч зөвшилцөх.</li> </ul> <p>б) Гэрээний үнийн дүнгийн 40 хувьтай тэнцэх дүнг дунд шатны тайланг хүлээн авч эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурснаар төлнө. Дунд шатны тайлан дараах бүтэцтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Дулааны магистраль шугамын өргөтгөлийн зураг төсөл /Улаанбаатар/” ажлын зураг төсөл боловсруулах ажлын дагуугийн зүсэлт, холбогдох бусад зураг төсөл дууссан байх.</li> </ul>

	с) Гэрээний үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх дүнг “Дулааны магистраль шугамын өргөтгөлийн зураг төсөл /Улаанбаатар/” ажлын зураг төслийг улсын экспертизээр хянуулсаны дараа.
6.5	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.05 хувь байна. Нийт гэрээний үнийн 10%-иас хэтрүүлэхгүй.
8.2	Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

		Ажлын зураг гүйцэтгэх график																									
д.д	Хийх ажил	Ажлын хөндөг	ИТ Ажилтан	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24
1	Трассын дагуу сувалгаа хийх	5	А.Цогт, Ц.Галт																								
2	Трассын газрын зураг чийглэх	21	Талар, ХХК																								
3	Трассын дагуу хэмжээг хийх	10	А.Цогт, А.Цолжаргал, Ц.Галт																								
4	Трассын төлөвлөлт хийх	10	А.Цогт, Ш.Батсайхан, А.Цолжаргал																								
5	Трассын төлөвлөлтийг "УБДС" ТӨХК-тай зөвшөөрүүлэх	5	А.Цогт																								
6	Трассын төлөвлөлтийг "УСУГ"-тай зөвшөөрүүлэх	5	А.Цогт, Ц.Галт																								
7	Трассын төлөвлөлтийг "ДИС-3" ТӨХК-тай зөвшөөрүүлэх	5	А.Цогт, Ц.Галт																								
8	Трассын төлөвлөлтийг "ДИС-3"-н орж буй ТЗ-ийн зөвшөөрөл авах	5	А.Цогт, Ц.Галт																								
9	Трассын төлөвлөлтийг НЕТГ-аартай зөвшөөрүүлэх	5	А.Цогт, Ц.Галт																								
10	Трассын төлөвлөлтийг ХНГ-аартай зөвшөөрүүлэх	5	А.Цогт, Ц.Галт																								
11	Трассын төлөвлөлтийг "УБЦТС" ТӨХК-тай зөвшөөрүүлэх	5	А.Цогт, Ц.Галт																								
12	Трассын төлөвлөлтийг ШУС ТӨХК-тай зөвшөөрүүлэх	5	А.Цогт, Ц.Галт																								
13	Трассын төлөвлөлтийг АЗХГ-аартай зөвшөөрүүлэх	5	А.Цогт, Ц.Галт																								
14	Трассын төлөвлөлтийг ГТҮБ-аартай зөвшөөрүүлэх	5	А.Цогт, Ц.Галт																								
15	Трассын төлөвлөлтийг Газрын албатай зөвшөөрүүлэх	5	А.Цогт, Ц.Галт																								
16	Трассын төлөвлөлтийг "ДИС-3"-н орж буй ТЗ-ийн зөвшөөрөл авах	10	"Ингеотех" ХХК																								
17	Зөвшөөрөлтэй тэйлэн	20	А.Цогт, Ш.Батсайхан, А.Цолжаргал																								
18	Зөвшөөрөлтэй тэйлэн	10	А.Цогт																								
19	Зөвшөөрөлтэй тэйлэн	40	А.Цогт, А.Рэнцэнсүрэн, А.Цолжаргал, Ц.Галт																								
20	Төвлөсөн трассын дагуу УХАТ-н ажлын зураг хийх	20	Ш.Батсайхан																								
21	Төвлөсөн трассын дагуу ГЦ-н ажлын зураг хийх	10	А.Цолжаргал, А.Цогт, А.Цолжаргал																								
22	Дунд шалтгайлал	20	С.Цэндэл, Л.Балсантулга																								
23	Холбогдох зөвшөөрлийг авах	10	А.Цогт, А.Рэнцэнсүрэн, А.Цолжаргал, Ц.Галт																								
24	Экспертиз	14																									
25	Төгсгөлийн тэйлэн	211																									



А.Цогт  
А.Цолжаргал

2021.06.15

473DBG/21/05084

**ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА**

**БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ -т**

“ЭРЧИМ ТӨСӨЛ ХХК” (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь “ДУЛААНЫ МАГИСТРАЛ ШУГАМНЫ ӨРГӨТГӨЛ БХБЯ/202103128” (цаашид “гэрээ” гэх) ажил гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй баталгааг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, 14210 Энхтайваны өргөн чөлөө 19 хаягт орших Худалдаа, Хөгжлийн банк (цаашид “Банк” гэх) нь Монгол Улсын “Иргэний хууль”-ийн 234.6, 457-р зүйлд үндэслэн гаргасан дараах баталгааг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс

**8,100,000.00 төгрөг**  
(Найман сая нэг зуун мянган төгрөг) –оос

хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг “БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ ” (цаашид “захиалагч” гэх)-ын өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга, тэмдэг бүхий бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан **8,100,000.00 төгрөг (Найман сая нэг зуун мянган төгрөг)** –ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ баталгааны дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь **АЖИЛ ДУУССАНААС ХОЙШ 7 ХОНОГ** хүчинтэй байна. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Худалдаа, Хөгжлийн банкны **ЗУУН АЙЛ САЛБАР**-т бичгээр хуруушиг.

Хүндэтгэсэн,

ЗУУН АЙЛ САЛБАРЫН ЗАХИРАЛ

 О.НЯМБАЯР



Банкны баталгааг QR код болон дараах холбоосоор хандаж баталгаажуулна уу.  
<https://www.tdbm.mn/verify.php>  
Баталгаажуулах код: 3592391A2A78C596

2010643

Багын бүрэлдэхүүн болон ажлын хуваарилалт

1. Техникийн болон удирдах ажилтнууд			
Нэр	Албан тушаал	Ажлын туршлага	Хариуцах ажил
А.Цогтжав	Захирал	27 жил зураг төслийн байгууллагад ажиллаж байгаа. Монгол улсын зөвлөх инженер.	Гэрээ байгуулах. Зураг төслийн ажлыг удирдан зохион байгуулж, холбох. Зохих байгууллагуудтай зөвшилцөх, холбогдох зөвшөөрлүүдийг авах. Төлбөр тооцооны асуудал шийдэх. Газар дээрх судалгаа хийх. Байнгын ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах.
А.Цогт	Дулааны инженер	42 жил зураг төслийн байгууллагад ажиллаж байгаа. Монгол улсын зөвлөх инженер.	Технологи, халаалт агаар сэлгэлт, гадна дулааны зураг төслийн техникийн удирдагч. Бүх тооцоо, зураглалд зөвлөгөө өгөх, хянах, баталгаажуулах.
А.Рэнцэнсүрэн	Дулааны инженер	21 жил зураг төслийн байгууллагад ажиллаж байгаа. Мэргэшсэн инженер.	Магистраль шугамын зураг төслийг боловсруулах. Техникийн шийдлийг техникийн удирдагчтай зөвлөлдөж шийдэх.
С.Цэмбэл	Барилгын инженер	38 жил зураг төслийн байгууллагад ажилласан. Зөвлөх инженер.	Барилга бүтээцийн хэсгийн тооцоо, зураг төсөл.
Ц.Галт	Дулааны инженер	9 жил зураг төслийн байгууллагад ажиллаж байгаа. Мэргэшсэн инженер.	Магистраль шугамын зураг төслийг боловсруулах. Техникийн шийдлийг техникийн удирдагчтай зөвлөлдөж шийдэх.
Ш.Батсайхан	Зөвлөх инженер	27 жил зураг төслийн байгууллагад ажиллаж байгаа. Монгол улсын зөвлөх инженер.	Гадна цэвэр ус, ариутгах татуургын зураг төслийг боловсруулах. Техникийн удирдагчтай хамтран шийдэл гаргах.
С.Бадамгарав	Төсөвчин	27 жил зураг төслийн байгууллагад ажиллаж байгаа. Монгол улсын тэргүүлэх төсөвчин.	Төсвийн техникийн удирдагч. Төсөв боловсруулах.
Ж.Батсүрэн	Инженер геологич	35 жил инженер геологийн чиглэлээр ажиллаж байгаа. Ахлах инженер геологич.	"Инжгеотех" ХХК-н ахлах инженер геологич. Хөрсний геологийн судалгаа хийж өгөх.
Лувсан	Геодезийн инженер		"Гал гэр" ХХК-н
2. Туслах ажилтнууд			
Нэр	Албан тушаал	Ажлын туршлага	Хариуцах ажил
Б.Бэрцэцэг	Инженер	2 жил зураг төслийн байгууллагад ажиллаж байгаа.	Магистраль шугамын зураг төслийг зөвлөх инженерийн удирдлага дор боловсруулах.
Э.Одбаяр	Техникч	4 жил зураг төслийн байгууллагад ажиллаж байгаа.	Магистраль шугамын зураг төслийг зөвлөх инженерийн удирдлага дор боловсруулах.
Ц.Тамир	Геологич	6 жил инженер геологийн чиглэлээр ажиллаж байгаа.	"Инжгеотех" ХХК-н инженер геологич. Хөрсний геологийн судалгаа хийж өгөх.

Зохиосон:  
Инженер  
Хянасан:  
Захирал



А.Цогт

А.Цогтжав